

Мэдлэгийн баримт бичиг

ТА-6883 REG Зүүн Азийн жендэрийн тэгш байдлыг түргэтгэх ногоон, хүртээмжтэй сэргэлт

Аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг ахиулах нь



Хураангуй

Энэхүү мэдлэгийн баримт бичиг нь “Эмэгтэй удирдлагатай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд (БЖДБЭ) зориулсан тойрог эдийн засаг (ТЭЗ) болон ногоон бизнесийн чиглэлээр чадавх бэхжүүлэх” төслийн хүрээнд гарсан судалгаа, бодлогын стратегийн зөвлөмжүүдийг багтаалаа. Тус төсөл нь 2022–2025 онд хэрэгжсэн ТА-6883 REG: “Зүүн Азийн жендэрийн тэгш байдлыг түргэтгэх ногоон, хүртээмжтэй сэргэлт” бүс нутгийн техникийн туслалцааны хүрээнд хийгдсэн юм.

Уг төслийг Азийн Хөгжлийн Банк (АХБ) санхүүжүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) дэмжин, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС Холбоо), Монголын Хараат Бус Судалгааны Хүрээлэн (IRIM), Хөгжлийн Шийдэл ТББ нар хамтран хэрэгжүүллээ.

Төсөл нь Улаанбаатар хот, Архангай болон Хөвсгөл аймгийн 400 гаруй БЖДБЭ-ийг хамруулсан бөгөөд хүнс, сав баглаа боодол, хог хаягдалтай холбоотой нийлүүлэлтийн сүлжээнд төвлөрч ажилласан ба үйл ажиллагааны хүрээнд тойрог эдийн засгийн боломж, сорилтыг судлах судалгаа, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлуудыг хийлээ. Түүнчлэн 16 шинэлэг ногоон санаачилгыг шалгаруулж, тоног төхөөрөмжийн дэмжлэг олгосон бөгөөд салбар хоорондын бодлогын хэлэлцүүлэг, олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулсныг онцлуштай. Жендэрт мэдрэмжтэй загварчлалын дагуу төслийн үйл ажиллагаа эмэгтэй удирдлагатай БЖДБЭ-д төвлөрч, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх санаачилга, манлайлал үзүүлж буй оролцогчдыг түлхүү дэмжсэнээрээ төсөл зорилгодоо хүрсэн.

Судалгааны үр дүнд тойрог эдийн засгийг нэвтрүүлэх замаар тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх томоохон боломж байгааг харуулсан бөгөөд энэ хүрээнд бизнесийн байгууллагуудын мэдлэг, санхүүжилтэд хандах боломж, бодлогын уялдаа холбооны дутагдал зэрэг тулгамдсан асуудлуудыг илрүүлсэн. Учир нь аялал жуулчлалын салбар нь Монгол Улсын ДНБ-ий 6.7%, үндэсний хөдөлмөр эрхлэгчдийн 7.2%-ийг бүрдүүлдэг¹ тул ТЭЗ-ийн шилжилтийг түргэтгэх стратегийн гол салбар байж чадах юм.



Зураг 1. Аялал жуулчлалын салбар дахь тойрог эдийн засаг ба жендэрт суурилсан хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг, 2024 оны 5 сарын 31-нд зохион байгуулав.

¹ COVID-19 цар тахлын өмнө аялал жуулчлал нь Монгол Улсын ДНБ-ий 7.2%, ажил эрхлэлтэд 7.6%-ийн хувь нэмэр оруулж байв (World Travel & Tourism Council, 2019)

Төслийн нөхцөл байдал ба хамрах хүрээ

Монгол Улсын аялал жуулчлалын салбар жил бүр ойролцоогоор 670 сая ам.долларын орлого бүрдүүлдэг² бөгөөд ялангуяа хөдөө орон нутагт эдийн засгийн чухал хөдөлгөгч хүч болдог билээ. Гэвч тус салбар нь нөөцийн үр ашиггүй хэрэглээ, хог хаягдлын менежментийн дэд бүтцийн дутагдал, алслагдсан газруудад байгаль орчинд үзүүлэх өндөр нөлөөлөл зэрэг тогтвортой байдлын томоохон сорилтуудтай тулгаран хэвээр байгаа нь асуудал юм.

Эдгээр сорилтыг шийдвэрлэхийн тулд төслийг жендэрийн мэдрэмжтэй байдлаар загварчилж, тогтвортой практик нэвтрүүлэхэд илүү идэвхтэй байдаг эмэгтэй удирдагчтай аж ахуйн нэгжүүдэд онцгой анхаарал хандуулав.

Техникийн туслалцааны төслийн зорилго нь дээрх сорилтуудыг жендэрт суурилсан арга барилаар шийдвэрлэхэд чиглэсэн бөгөөд эмэгтэйчүүдийн удирдсан аж ахуйн нэгжүүд нь тогтвортой үйл ажиллагаа нэвтрүүлэхэд илүүтэй бэлэн байдалтай байдгийг харгалзаж үзэв. Тиймээс тус санаачилга нь аж ахуйн нэгжийн түвшинд чадавх бэхжүүлэхээс эхлэн үндэсний хэмжээний бодлогын хэлэлцүүлэг хүртэл олон түвшинд хэрэгжсэн бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), санхүүгийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг гол оролцогч талуудыг хамруулсан онцлогтой.

Оролцогч талуудын оролцоо ба хамтын ажиллагаа

Шэньжэнь болон Хонг Конг руу хийсэн туршлага судлах аялалд эмэгтэй зургаан оролцогч оролцож олон улсын мэдлэг, туршлагыг солилцсон юм. Түүнчлэн бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (CAREC) цахим форумоор дамжуулан үргэлжлүүлсэн бөгөөд 163 оролцогч оролцсон. Гол түншээр Азийн Хөгжлийн Банк (АХБ), БОУАӨЯ, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС Холбоо), Монголын Хараат Бус Судалгааны Хүрээлэн (IRIM), Хөгжлийн Шийдэл ТББ-ууд байлаа.

Тус төсөл нь аялал жуулчлалын экосистемийг хамарсан өргөн цар хүрээтэй оролцоог хангаж, нийт 400 БЖДБЭ-ийг (222 үйлдвэрлэгч, 178 үйлчилгээ үзүүлэгч) хамруулсан бөгөөд 22 гишүүнтэй олон талт ажлын хэсэг байгуулж, төрийн байгууллагууд, банк болон банк бус санхүүгийн байгууллагууд, бизнесийн холбоод болон төрийн бус байгууллагуудын уялдааг ханган ажиллалаа.

Судалгааны гол үр дүн

1. Тойрог эдийн засгийн талаарх ойлголт ба мэдлэгийн түвшин

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос (ТоС Холбоо) боловсруулж, хэрэгжилтээс өмнө баталсан аргачлал, хамрах хүрээний дагуу хийгдсэн аж ахуйн нэгжүүдийн үнэлгээ³ нь анхан шатны мэдлэг болон практик ойлголтын хооронд мэдэгдэхүйц зөрүү байгааг харуулсан юм. Судалгаанд хамрагдсан БЖДБЭ-үүдийн 66.8% нь тойрог эдийн засгийн ойлголттой танилцаж байсан бол ердөө 6.5% нь хог хаягдлын энгийн менежментээс давсан бүрэн ойлголттой байсан. Ихэнх аж ахуйн нэгжүүд ТЭЗ-ийг зөвхөн хуванцар дахин боловсруулахтай холбон ойлгож, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг оновчтой болгох, нөхөн сэргээгдэх бизнесийн загвар, уламжлалт борлуулалтыг орлох үйлчилгээний хэлбэр зэрэг өргөн боломжийг анзаараагүй байсан.

Энэхүү ойлголтын дутмаг байдал нь аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны гүйцэтгэл, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шийдлүүдийг тодорхойлох, хэрэгжүүлэх чадамжийг хязгаарлаж буй. Цаашлаад энэ нь ТЭЗ-ийн зарчмыг аялал жуулчлалын үйл ажиллагаанд бодитоор хэрэгжүүлэхийн тулд бүх талт чадавх бэхжүүлэх цогц арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

2. Зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийн зөрүү

Судалгаагаар байгаль орчинд хариуцлагатай хандах талаар жуулчдын хүлээлт болон салбарын өнөөгийн практикийн хооронд томоохон зөрүү байгааг тогтоосон. Жуулчдын санал асуулгаар:

- 98% нь хоггүй аялал жуулчлал нь очих газрын сонголтод чухал гэж үздэг
- 86% нь хог ангилан ялгах иж бүрэн системтэй байрыг илүүд үздэг

Гэсэн хэдий ч, үнэлгээнд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн:

- 50% нь анхан шатны хог хаягдлын менежменттэй
- 14% нь байгаль орчны гүйцэтгэлийн хяналт болон бүтээгдэхүүний нөлөөллийн үнэлгээ хийдэг.

Энэхүү зөрүү нь Монголын аялал жуулчлалын салбарт байгальд ээлтэй үйлчилгээ сонирхдог олон улсын жуулчдыг татах өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөхөөс гадна ашиг олох боломжийг алдсаныг харуулав.

² COVID-19 цар тахлын өмнөх жилүүдэд аялал жуулчлалаас жил бүр ойролцоогоор 670 сая ам.долларын орлого олдог байсан (WTTC, 2019).

³ ТА-6883 ТЭЗ үнэлгээ (IRIM, ТоС Холбоо, Хөгжлийн Шийдэл, 2022 он; Хавсралт 1).

Судалгаанд оролцсон жуулчдын 73% нь тогтвортой байдлыг баталгаажуулсан үйлчилгээнд нэмэлт төлбөр төлөхөд бэлэн гэсэн нь ТЭЗ-ийн практикийг өргөн хүрээнд нэвтрүүлэхэд санхүүгийн хөшүүрэг болох боломжтойг илтгэж байна.

3. Санхүүжилт ба дэд бүтцийн хязгаарлалт

Оролцсон аж ахуйн нэгжүүдийн зүгээс тойрог эдийн засгийг хэрэгжүүлэхэд хамгийн том саад нь тохиромжтой санхүүжилтэд хандах боломж болон шаардлагатай дэд бүтцийн дутагдал гэж тууштай тэмдэглэсэн. Одоогийн ногоон санхүүжилтийн хөтөлбөрүүдэд ихэвчлэн газар өмчлөх шаардлага зэрэг шалгуур орсон байдаг нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл эмэгтэйчүүд удирддаг аялал жуулчлалын БЖДБЭ-д маш хүндээр тусч байна.

Тойрог эдийн засагт чиглэсэн техникийн дэмжлэгийн үйлчилгээ болон эдийн засгийн үр ашиг, хэрэгжих боломжийг үнэлэх хэрэгслүүдийн дутагдалтай байдал нь эдгээр аж ахуйн нэгжүүдийн ТЭЗ-ийн шийдлийг боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг хязгаарлаж байна. Мөн алслагдсан аялал жуулчлалын бүсүүдэд хог хаягдлын менежментийн дэд бүтэц сул байгаа нь ялангуяа Монголын гол давуу тал болох байгалийн аялал жуулчлалын байршлуудад ТЭЗ-ийг цогцоор хэрэгжүүлэх боломжийг үгүй хийж байна.

Одоогийн гэрчилгээжүүлэлт болон эко тэмдэглэгээний системүүд нь олон улсын стандарттай нийцэхгүй, зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц итгэлцлийг хангаж чадахгүй байгаагаас ТЭЗ-ийн хөрөнгө оруулалтыг өдөөх боломжийг хангалттай бүрдүүлж чадахгүй байгаа юм.

4. Бодлогын болон институцийн зохицуулалтын дутагдал

Монгол Улс “Алсын Хараа 2050” бодлогоор дамжуулан ногоон хөгжлийн чиг баримжаагаа тодорхойлсон хэдий ч аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогын хүрээ болон институц хоорондын уялдаа, зохицуулалтын механизмд ноцтой дутагдал байгааг судалгаагаар тогтоосон. Аялал жуулчлалд тусгайлан чиглэсэн, нэгдсэн ТЭЗ-ийн стратеги одоогоор байхгүй бөгөөд одоо хэрэгжиж буй жижиг, дунд бизнесийн зээлийн хөтөлбөрүүд нь ТЭЗ-ийн үзүүлэлт болон үр дүнг хянах чадваргүй байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, аялал жуулчлал, санхүүгийн яамдууд болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хоорондын зохицуулалт хангалтгүй байгаа нь ТЭЗ-ийг иж бүрнээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд саад болж буй. Түүнчлэн одоогийн “Ногоон навч”⁴ зэрэг эко тэмдэглэгээний хөтөлбөрүүд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO стандартуудтай нийцэхгүй байгаа нь байгаль орчинд мэдрэг олон улсын жуулчдыг татах, зах зээлийн үр нөлөөг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна.



Стратегийн зөвлөмжүүд

Нэн тэргүүнд хэрэгжүүлэх чиглэлүүд		
Санхүүгийн механизмыг шинэчлэх	Эко тэмдэглэгээний тогтолцоог сайжруулах	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт
Монгол Улсын аялал жуулчлалын сэргэлтийн хөтөлбөрийн хүрээнд нийт 55 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг аялал жуулчлалын бизнесүүдэд олгохоор шийдвэрлэсэн байдаг ⁵ . Энэхүү одоогийн санхүүгийн механизм нь ТЭЗ-ийн шалгуур үзүүлэлтүүдийг — тухайлбал бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ, орон нутгаас худалдан авалтыг дэмжих урамшуулал, хог хаягдалгүй үйл ажиллагааны зорилт гэх мэт — зээлийн шалгуурт тусгах боломж	Монгол Улсын эко тэмдэглэгээний тогтолцоог ISO 14024 болон ISO 14025 стандарттай нийцүүлэн, гуравдагч этгээдийн баталгаажуулалтын тогтолцоо болон гүйцэтгэлийг цахимаар хянах систем бүхий цогц шинэчлэл хийх шаардлагатай. Ийнхүү итгэлцэл, олон улсын хүлээн зөвшөөрөл нэмэгдсэнээр аялал жуулчлалын бизнесүүдийн байгаль орчны гэрчилгээний зах зээлийн үнэлгээ өсөх юм.	ТЭЗ-ийн үйл ажиллагааг алслагдсан аялал жуулчлалын бүсүүдэд дэмжихийн тулд төвлөрсөн бус бордоо боловсруулах байгууламж, сав баглаа боодлыг буцаан авах схем, хүлэмжийн хий бага ялгаруулдаг тээврийн системд стратегийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Ийм дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хамгийн их жуулчин хүлээн авдаг болон байгаль орчны хувьд эмзэг бүс нутагт тэргүүн ээлжинд чиглүүлэх нь зүйтэй.

⁴ Green Leaf™ эко стандарт нь Монгол Улсад аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй гол эко тэмдэглэгээний санаачилга бөгөөд гуравдагч талын баталгаажуулалтын стандартыг Ecolabel Index-д тусгасан байдаг.

⁵ Монгол Улсын Засгийн газар “10 их наядын эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөө”-ний хүрээнд аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдэд 55 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгосон (Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоол).

олгож байна. Нийтийн санхүүжилтийг ТЭЗ-ийн зарчимтай уялдуулах нь төрөөс дэмжигдсэн хөрөнгө оруулалтыг илүү тогтвортой аж ахуйн нэгжүүд рүү чиглүүлж, тойрог шийдлүүдэд зах зээлийн эрэлт бий болгоно.		
Дунд хугацааны хөгжлийн зорилтууд		
Үндэсний стратеги боловсруулах	Техникийн туслалцааны дэд бүтэц	Боловсролын хөтөлбөрт нэгтгэх
2030 он гэхэд аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг нэвтрүүлэх үндэсний хэмжээний иж бүрэн стратегийг боловсруулах шаардлагатай. Түүнчлэн стратегидаа “Алсын хараа 2050”-ын салбар бүрийн хэрэгжилтийн төлөвлөгөөнд тусгагдах тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тусгаж өгөх ёстой. Үүнд ТЭЗ-ийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, материалын дахин ашиглалтын түвшин, ТЭЗ-ийн арга хэмжээний улмаас буурсан хүлэмжийн хийн ялгарлын тоон үнэлгээ зэрэг багтана.	Зорилтот аймгуудад ТЭЗ-ийн тусламжийн лавлах төв эсвэл шилдэг туршлагын төвүүдийг байгуулах нь аж ахуйн нэгжүүдэд аудит хийх, инновац хөгжүүлэх, ТЭЗ-ийн арга хэрэгсэл, технологид нэвтрэх боломжийг тасралтгүй дэмжих нөхцөлийг бүрдүүлэх давуу талтай. Эдгээр төвүүд нь бүсчилсэн мэдлэгийн солилцоо, чадавх бэхжүүлэх төв байршил болж ажиллах юм.	ТЭЗ-ийн агуулгыг мэргэжлийн боловсрол болон аялал жуулчлалын сургалтын хөтөлбөрт нэгтгэж, холбогдох яамд болон аялал жуулчлалын холбоодтой хамтран хэрэгжүүлэх нь чухал бөгөөд ингэснээр ирээдүйн ажиллах хүч ТЭЗ-ийн мэдлэг, ур чадварыг мэргэжлийн үндсэн шаардлагын нэг хэсэг болгон эзэмших боломжтой болно.
Бодлогын хэрэгжилтийн хүрээ		
Зохицуулалтын механизм	Гүйцэтгэлийн хяналт	Худалдан авалт ба хөрөнгө оруулалтын уялдаа
Сав баглаа боодол болон аялал жуулчлалын хүнсний салбарт үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын (Extended Producer Responsibility, EPR) тогтолцоог нэвтрүүлснээр бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн нөлөөлөлд тодорхой зохицуулалт бий болж, тойрог загварт суурилсан үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжих эдийн засгийн хөшүүрэг бүрэлдэнэ. Үүнийг “Бохирдуулагч төлдөг” (Polluter Pays) зарчимтай уялдуулан, ялгаруулалт болон хог хаягдлын хэмжээнд суурилсан ил тод эко төлбөрийн тогтолцоогоор баталгаажуулах хэрэгтэй.	Төрийн дэмжлэгтэйгээр ногоон санхүүжилт авсан аж ахуйн нэгжүүд тойрог эдийн засгийн талаарх тайлан болон гүйцэтгэлийн мэдээллийг ил тод тайлагнах үүрэгтэй байх нь зүйтэй. Ингэснээр хариуцлагын механизмтай болж, бодлогын сайжруулалт, нөлөөллийн үнэлгээнд шаардлагатай өгөгдөл бий болно. Ийм төрлийн шаардлага нь цаашид бусад байгууллагуудад хамаарах байгаль орчны тайлагналын шинэ жишиг тогтоох эхлэл болох юм.	Мөн ТЭЗ-ийн сургалтын модулиудыг мэргэжлийн боловсрол болон аялал жуулчлалын сургалтын хөтөлбөрт тусгаж, холбогдох яамд болон салбарын холбоодтой хамтран хэрэгжүүлэх нь чухал. Энэ нь ирээдүйн ажиллах хүчийг ТЭЗ-ийн мэдлэг, ур чадвараар хангах стандарт шийдэл болно.



Хөтөлбөрийг өргөжүүлэх

Хоёрдугаар үе шатны хэрэгжилтийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, хөдөөгийн орлогыг төрөлжүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой биологийн олон янз байдалд суурилсан эко-аялал жуулчлалын санхүүжилтийн загварыг туршин хэрэгжүүлэх боломжтой. Үүний гол бүрэлдэхүүн хэсгүүдэд Монгол Улсын шинэчлэгдсэн ногоон стандартад нийцсэн эко-аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог боловсруулах, эко-аялал жуулчлалыг Тогтвортой хөгжлийн зорилтын (ТХЗ) санхүүжилтийн таксономид⁶ нэгтгэх, малчдын хоршоо болон хөдөөгийн бизнес эрхлэгчдэд зориулсан ESG эсвэл тогтвортой байдалд суурилсан зээлийн⁷ загварыг боловсруулах ажлууд багтана.

ТА-6883 төслийн онцлог нь ногоон салбаруудад шинэ санаачилга, инновацийг дэмжих чиглэлд байсан бөгөөд эко даавуун уутнаас эхлээд тогтвортой аялал жуулчлал хүртэл олон төрлийн бизнесийн туршилтыг боломжтой болгосон ч салбар хоорондын уялдаа, хамтран суралцах орчныг хангах тал дээр хязгаарлагдаж байлаа. Төслийг хэрэгжүүлэгчдийн зүгээс ижил салбарын төслүүдийг кластер хэлбэрээр нэгтгэснээр туршлага солилцоог нэмэгдүүлж, нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлж, салбарын нэгдмэл өөрчлөлтийг дэмжих боломжтой гэж онцолж байв.

Түүнчлэн уг хөтөлбөр нь цаашид хэрэгслийг бодит ажил хэрэг болгоход шаардлагатай техникийн туслалцааг хангах зорилгоор экспертүүдийн бүлэг байгуулах, бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг өрнүүлэх зэргээр дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсын хамгаалалттай газар нутгийн сүлжээг түшиглэн биологийн олон янз байдалд суурилсан санхүүжилтийн шийдлүүдийг загварчлах нь энэхүү ажлын нэг хэсэг байх юм. Энэ нь ТХЗ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн (NDC) зорилтуудыг хангахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ ногоон ажлын байр нэмэгдүүлэх, хот руу чиглэсэн шилжилтийг бууруулах, хүртээмжтэй хөдөөгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Түүнчлэн хөтөлбөрийн тогтвортой байдлын хүрээнд, тэтгэлгийг урт хугацааны институцийн тогтолцоонд уялдуулах нь чухал гэж практик хэрэгжүүлэгчид санал нэгдсэн. Үүнд, тойрог эдийн засгийн сургалтын модуль хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, дээд боловсролын тогтолцоонд тусгах ажлууд багтах юм.



Бодлогын уялдааг хангах

Монгол Улсын тойрог эдийн засгийн амбицийг үндэсний бодлогын баримт бичгүүдэд бүрэн тусгахын тулд бодлогын уялдаа, хамтын ажиллагааг хамгийн дээд түвшинд хүргэх шаардлагатай. Алсын хараа 2050-ийг хэрэгжүүлэх үйл явц болон ТХЗ-ийн санхүүжилтийн таксономийн шинэчлэлтэй уялдуулан Тойрог эдийн засгийн бодлогын тусгай форумыг байгуулж, яамдууд хооронд тодорхой чиг үүрэг, хэрэгжилтийн хугацаатай замын зураглал боловсруулж ажиллах хэрэгтэй.

Уг форум нь тойрог эдийн засгийн зорилтыг төрийн худалдан авалтад (тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг бий болгох), жижиг дунд бизнесийн зээлийн шалгуурт, NDC тайлагналд тусгаж, санхүүгийн урамшуулал, эко тэмдэглэгээний шинэчлэл, хөнгөлөлттэй зээлийн схемүүдийг уялдуулах чухал механизм болно. Жил бүрийн хэрэгжилтийн үнэлгээ болон яамдууд хоорондын бүтэцтэй хамтын ажиллагаа нь ТА-6883 төслийн дараа ч үргэлжлэх тогтолцоог бий болгох боломжтой.



Стандарт боловсруулах

ISO стандартуудтай нийцсэн эко тэмдэглэгээний хэрэгжилтийн нарийвчилсан төлөвлөгөөг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, ToC холбоо болон олон улсын түншүүд хамтран боловсруулна. Энэхүү төлөвлөгөөнд хэрэгжилтийн тодорхой үе шат, институцүүдийн үүрэг, Монголын байгаль орчны

⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP), Азийн Хөгжлийн Банк (ADB). (2024 оны 12 сар). Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын Санхүүжилтийн Таксономийн туршилт [PDF].

гэрчилгээжүүлэлтийн техникийн шалгуурыг тусгах ёстой бөгөөд ISO 14024 болон ISO 14025 стандартуудтай уялдуулах шаардлагатай.

Нэн чухал нь эдгээр хэрэгжилтийн үе шатуудыг тогтвортой санхүүжилтийн үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжих татаасын схем болон ногоон зээлийн шалгууртай шууд уялдуулах хэрэгтэй. Баталгаажсан эко тэмдэглэгээг зээлийн шалгуурт тусгах нь ногоон хөрөнгө оруулалтыг жинхэнэ тогтвортой аж ахуйн нэгжүүд рүү чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ил тод байдал, хөрөнгө оруулагчдын итгэлцэл, олон улсын хүлээн зөвшөөрлийг нэмэгдүүлэх юм.



Бүс нутгийн оролцоо

Бүс нутгийн түвшинд Монгол Улс бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжихийг зорьсон CAREC Аялал жуулчлалын стратеги 2030⁸ баримт бичгийг түшиглэх боломжтой. Түүнчлэн Европын Холбооны Global Gateway санаачилгын хүрээнд Төв Азийн тойрог эдийн засгийн бодлогын уялдааг дэмжих олон улсын зөвлөмжтэй нийцүүлэх нь зүйтэй⁹. Монгол Улсын эко-аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт болон биологийн олон янз байдалд суурилсан санхүүжилтийн туршлагыг CAREC-ийн аялал жуулчлалын салбарын кластер уулзалтууд болон бүс нутгийн форумуудаар дамжуулан хуваалцах бүрэн боломжтой юм.

Global Gateway санаачилгын олон талт зөвлөлдөх уулзалтын хүрээнд үргэлжлүүлэн хамтран ажиллах нь туршлага хуваалцах, эко тэмдэглэгээний харилцан нийцтэй стандартууд, хил дамнасан ногоон санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг болно. Энэхүү давхар стратеги нь Монгол Улсыг бүс нутгийн тойрог эдийн засагт суурилсан аялал жуулчлалын манлайлагч болгож, илүү өргөн цар хүрээтэй техник болон санхүүгийн хамтын ажиллагааг татах нөхцөлийг бүрдүүлнэ.

Дүгнэлт



Монгол Улсын 400 аялал жуулчлалын аж ахуйн нэгжид хийсэн энэхүү иж бүрэн үнэлгээ нь зах зээлийн асар том боломжийг нээж, дэлгэн харуулж байна. Олон улсын жуулчдын 98% нь хоггүй аялал жуулчлалыг чухалчилдаг бөгөөд 73% нь тогтвортой байдлыг нотлох үйлчилгээнд өндөр үнэ төлөхөд бэлэн байгаа боловч дөнгөж 6.5% нь ТЭЗ-ийн мэдлэгтэй байна. Аялал жуулчлалын салбар нь жилд 670 сая ам.долларын орлого бүрдүүлж, Монгол Улсын ажиллах хүчний 7.2%-ийг хангаж буй тул зах зээлийн эрэлт, салбарын чадамжийн хоорондох зөрүү нь нэг талаас эрсдэл, нөгөө талаас эдийн засгийн шинэ боломж юм.

Төслийн хүрээнд 400 аж ахуйн нэгж, 22 гишүүнтэй олон талт ажлын хэсгийг байгуулсан нь Монголын аялал жуулчлалын салбар өөрчлөлтөд бэлэн байгааг харуулж буй. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн идэвхтэй оролцоо, аялал жуулчлалын салбарт чиглэсэн 55 тэрбум төгрөгийн санхүүжилт нь ТЭЗ-ийн зарчмыг аялал жуулчлалын сэргэлтийн бодлогод уялдуулах ховор боломжийг нээж өглөө.

Түүнчлэн төслийн жендэрийн мэдрэмжтэй загвар нь эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүд илүү тогтвортой байдалд хандсан байгааг нотолсон бөгөөд энэ нь ТЭЗ-ийг нэвтрүүлэх, хүртээмжтэй эдийн засгийн хөгжлийг урагшлуулах баттай гарц болж байна. Төслийн энэхүү ололт нь Монгол Улсыг байгаль орчин, жендэрийн тэгш байдлыг зэрэг шийдвэрлэх ТЭЗ-ийн шийдлийг амжилттай хэрэгжүүлэх чадамжтай хэмээх онцгой өрсөлдөх чадвартай болгож байна.

Харин энэ боломжийг бодит болгохын тулд бодлого, санхүүжилт, дэд бүтэц, чадавх бэхжүүлэлтийн түвшинд яаралтай, уялдаа холбоотой арга хэмжээ авах шаардлагатай юм. Судалгаагаар зах зээлийн эрэлт болон салбарын чадамжийн хоорондох зөрүүг арилгахад чиглэсэн тодорхой, хэрэгжүүлэх боломжтой интервенцүүдийг тодорхойлсон бөгөөд. Үүнд: санхүүгийн механизмд ТЭЗ-ийн шалгуур тусгах, ISO стандарттай нийцсэн эко тэмдэглэгээний тогтолцоо бүрдүүлэх, өндөр аялал жуулчлал бүхий аймгуудад техникийн туслалцааны дэд бүтэц хөгжүүлэх ажлууд багтлаа.

⁷ Азийн Хөгжлийн Банк. (2023 оны 11 сарын 20). АХБ, Говь компани Монгол Улсад уур амьсгалд тэсвэртэй ноолуурын үнэ цэнийн сүлжээг дэмжих тогтвортой байдлын үзүүлэлттэй зээлийн гэрээнд гарын үсэг зурав [Хэвлэлийн мэдээ].

⁸ Азийн Хөгжлийн Банк. (2020). CAREC-ийн Аялал Жуулчлалын Стратеги 2030 [PDF].

⁹ Европын холбооны Гадаад харилцааны алба; SWITCH-Asia Бодлогын дэмжлэгийн хэсэг. (2025 оны 5 сарын 22–23). Төв Азийн Олон Талт Зөвлөлдөх Уулзалт: Тогтвортой Хэрэглээ, Үйлдвэрлэл болон Тойрог Эдийн Засгаар дамжуулан Бодлогын Зорилтуудыг Бэхжүүлэх нь [PDF].

Харин хэрэгжилтийг удаашруулах нь Монгол Улсыг байгаль орчны үзүүлэлт нь зочлох газрын сонголт, үнэ тогтооход шийдвэрлэх нөлөөтэй болсон дэлхийн жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа алдах эрсдэлд оруулж болзошгүй юм. Тиймээс хэрэгжилтийг даруй эхлүүлж, аялал жуулчлалын зээлүүдэд ТЭЗ-ийн шалгуур нэвтрүүлэх, эко тэмдэглэгээний тогтолцоог бүрдүүлэх, орон нутгийн техникийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь стратегийн бодлого, яам хоорондын зохицуулалт, олон улсын хамтын ажиллагааг хөтлөх онцгой байр суурьтай. Тиймээс энэхүү баримт бичиг нь Алсын хараа 2050 болон тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн хэрэгжилтийн тодорхой чиглэлийг санал болгож байна.

Монгол Улс яг одоо шийдвэрлэх мөчид тулж ирлээ. Цаашид бид тогтвортой аялал жуулчлалын салбарт тойрог эдийн засгийн манлайлагч болж, өндөр чанартай олон улсын жуулчдыг татан, хөгжиж буй орнуудын хувьд жишиг загвар бий болгох бүрэн боломжтой. Энэхүү мэдлэгийн баримт бичигт туссан нотолгоо, оролцогч талуудын дэмжлэг, бодлогын зөвлөмжүүд нь Монгол Улсыг энэхүү түүхэн боломжийг ашиглан аялал жуулчлалыг тогтвортой эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болгон хөгжүүлэх үндэс суурь болно.

ТА-6883 төслийн хэрэгжилтийн үеэр гурван үндэсний байгууллагыг хамарсан хамтарсан консорциумын оновчтой загварыг туршсан нь өндөр үр дүнтэй туршлага болсныг онцольё. IRIM, Development Solutions, болон ToC Холбоо нь тус бүр судалгаа, чадавх бэхжүүлэлт, бодлогын дэмжлэгийн чиглэлээр харилцан бие биенээ нөхсөн туршлага, чадвараа нийлүүлснээрээ ажлаа үр дүнтэй хуваарилах, орон нутгийн хэрэгцээ, онцлогт нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, техникийн хувьд нарийн төвөгтэй хөтөлбөрийг саадгүй хэрэгжүүлж чадлаа.

Энэхүү туршлага нь үндэсний судалгааны байгууллага болон ТББ-уудыг хамтран ажиллуулахын давуу талыг харуулсан бөгөөд ТЭЗ зэрэг дэлхийн хандлагыг орон нутгийн шийдэл, бодит хэрэгжилтэд амжилттай уялдуулах ирээдүйн техникийн туслалцааны санаачлагуудад энэхүү загварыг түгээн хэрэглэх боломжтойг нотолж байна.

Эх сурвалж болон Хавсралтууд



Мэдээллийн эх сурвалжууд

1. Азийн хөгжлийн банк. (2021). ТА-6883 REG: Зүүн Азийн жендэрийн тэгш байдлыг түргэтгэх ногоон, хүртээмжтэй сэргэлт – Төслийн зураглалын баримт бичиг. АХБ.
2. IRIM, ToC Холбоо, Хөгжлийн Шийдэл ТББ. (2022). Монголын аялал жуулчлалын салбар дахь тойрог эдийн засгийн цогц үнэлгээний тайлан. (Хавсралт 1, Хавсралт 2-ыг үзнэ үү.)
3. МУ-ын Засгийн газар. (2020). “Алсын Хараа 2050” – Монгол Улсын үрт хугацааны хөгжлийн бодлого.
4. ToC Холбоо. (2024). Аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдэд зориулсан эко тэмдэглэгээ ба ногоон санхүүжилтийн бодлогын зөвлөмж. (Хавсралт 11, Хавсралт 12-ыг үзнэ үү.)
5. Олон улсын стандартын байгууллага. (2018). ISO 14024:2018 Байгаль орчны шошго болон тунхаглал – I төрөл: Байгаль орчны шошгололтын зарчим ба журам.
6. Олон улсын стандартын байгууллага. (2006). ISO 14025:2006 Байгаль орчны шошго болон тунхаглал – III төрөл: Байгаль орчны тунхаглалын зарчим ба журам.

Хавсралтууд

ТА-6883 REG:

- Хавсралт 1. Монголын аялал жуулчлалын салбар дахь тойрог эдийн засгийн цогц үнэлгээний тайлан
- Хавсралт 2. Үнэлгээний хураангуй тайлан
- Хавсралт 3. Төслийн товч танилцуулга
- Хавсралт 4. Ажлын хэсгийн уулзалтын тайлан
- Хавсралт 5. Ажлын хэсгийн бодлогын зөвлөмж
- Хавсралт 6. Бодлогын хэлэлцүүлгийн тайлан
- Хавсралт 7. Ажлын хэсгийн удирдамж
- Хавсралт 8. Туршлага судлах аяллын тайлан (Шэньжэнь ба Хонг Конг)
- Хавсралт 9. КАРЕК цахим форумын хураангуй
- Хавсралт 10. Ажлын хэсгийн хаалтын уулзалтын тайлан
- Хавсралт 11. Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
- Хавсралт 12. Менторшип хөтөлбөрийн тайлан
- “Эдийн засгийн ногоон шилжилт” (SOGE) төсөл:**
- Хавсралт 13. Эко тэмдэглэгээний бодлогын зөвлөмж
- Хавсралт 14. Төслийн бодлогын товч тэмдэглэл